# ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2019 оны 12 сарын 16 өдөр Дугаар 561 Улаанбаатар хот

**Үндсэн хөрөнгө балансаас балансад шилжүүлэх зөвшөөрөл олгох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2, 31 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны “Зөвшөөрөл олгох тухай” 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх, журам”-ын 5.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн, цаашид ашиглах боломжгүй нийт 763,348,417.65 (долоон зуун жаран гурван сая гурван зуун дөчин найман мянга дөрвөн зуун арван долоон төгрөг жаран таван мөнгө) төгрөгийн балансын үнэ бүхий 11 ширхэг автомашиныг хавсралтад заасны дагуу балансаас балансад шилжүүлсүгэй.

2. “Эрдэнэт үйлдвэр” төрийн өмчит үйлдвэрийн газрын ерөнхий захирал Х.Бадамсүрэн, Дорнод аймаг дахь Гаалийн газрын дарга Б.Винтов, “Орхон АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Цогтгэрэл, “Булган АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Батсайхан, “Харгуй” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Ч.Алтанзаяа, “Хөвсгөл АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Б.Галбадрах, “Завхан АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал М.Болд нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Үйлдвэрийн газрын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор хавсралтад заасан үндсэн хөрөнгийг шилжүүлэх ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг үнэлж, санхүүгийн тайланд тусгах;

2.3 .Хөрөнгийн хөдлөлийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.4. Арга хэмжээний биелэлтийг 2020 оны 1 дүгээр улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГА З.МЭНДСАЙХАН

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН ДАРГА А.АРИУНБОЛД

0001223

D:\Huraldaanii material\2019 on\2019.12.16 №25.docx

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн
561... дугаар тогтоолын хавсралт

## "ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ АВТОМАШИНЫ ЖАГСААЛТ

| Д/д | Автомашины марк, улсын дугаар, арал | Ашиглалтад орсон он | Балансын үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэх өртөг (төгрөг) | Шилжүүлэх байгууллагын нэр |
|---|---|---|---|---|---|---|
| | **Автотээврийн цех** | | | | | |
| 1 | KIA BONGO, 97-25 ОРХ, Хагас ачааны, арлын дугаар KNCSHY74CBK516043 | 31.12.2010 | 33,921,181.73 | 33,921,181.73 | - | Дорнод аймгийн Гаалийн газар |
| 2 | KIA BONGO, 97-26 ОРХ, Хагас ачааны, арлын дугаар KNCSHY74CBK515763 | 31.12.2010 | 33,921,181.73 | 33,921,181.73 | - | "Хөвсгөл АЗЗА" ТӨХК |
| 3 | Цамхагт өргөгч 900, 26-88 ОРХ, арлын дугаар LWLDNR/HX7L018365 | 31.10.2007 | 90,997,460.07 | 90,997,460.07 | - | "Булган АЗЗА" ТӨХК |
| 4 | Краз 65032-043, 07-61 ОРО, Авто өөрөө буулгагч, арлын дугаар 40795714 | 31.05.2004 | 69,050,486.70 | 69,050,486.70 | - | "Орхон АЗЗА" ТӨХК |
| 5 | Чирэгч трактор К701МА-12-01-ТСУ ГР 632, арлын дугаар 489356 | 30.11.2006 | 161,552,600.00 | 161,552,600.00 | - | "Орхон АЗЗА" ТӨХК |
| 6 | Автокран МКТ-25,8, 16-39 ОРХ, арлын дугаар 53370260007380 | 30.06.2007 | 202,537,932.64 | 202,537,932.64 | - | "Орхон АЗЗА" ТӨХК |
| 7 | Хьюндай Старекс, 20-01 ОРА, арлын дугаар KMJWWH7WP6U699010 | 29.04.2006 | 42,964,575.00 | 42,964,575.00 | - | "Хөвсгөл АЗЗА" ТӨХК |
| 8 | УАЗ 39094 /фермер/, 62-57 ОРА, Хагас ачааны, арлын дугаар 60471228 | 30.09.2006 | 11,100,000.00 | 11,100,000.00 | - | "Хөвсгөл АЗЗА" ТӨХК |
| | **Ус хангамжийн цех** | | | | | |
| 9 | Тоёота Ландкруйзер 80, 96-58 ора, арлын дугаар HDI81-OO45599 | 30.09.2004 | 40,000,000.00 | 40,000,000.00 | - | "Завхан АЗЗА" ТӨХК |
| | **Холбоо мэдээллийн технологи, автоматжуулалтын цех** | | | | | |
| 10 | KIA BONGO, 33-61 ОРО, арлын дугаар KNCSHY71CC7589449 | 30.09.2011 | 34,338,425.00 | 34,338,425.00 | - | "Харгуй" ТӨХК |

| Д/д | Автомашины марк, улсын дугаар, арал | Ашиглалтад орсон он | Балансын үнэ (төгрөг) | Хуримтлагдсан элэгдэл (төгрөг) | Үлдэх өртөг (төгрөг) | Шилжүүлэх байгууллагын нэр |
|---|---|---|---|---|---|---|
| | **Сувилал** | | | | | |
| 11 | Хьюндай Старекс, 06-26 ОРХ, арлын дугаар KMJWA37HABU302853, Түргэн тусламжийн автомашин | 31.12.2010 | 42,964,574.78 | 42,964,574.78 | - | "Булган АЗЗА" ТӨХК |
| **Балансаас балансад шилжүүлэх тээврийн хэрэгслийн нийт дүн** | | | **763,348,417.65** | **763,348,417.65** | - | |
| | | | **(долоон зуун жаран гурван сая гурван зуун дөчин найман мянга дөрвөн зуун арван долоон төгрөг жаран таван мөнгө)** | **(долоон зуун жаран гурван сая гурван зуун дөчин найман мянга дөрвөн зуун арван долоон төгрөг жаран таван мөнгө)** | | |